

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтэс
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.1.	Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.	Үйл ажиллагааны зардлаар	-	-	-	-	Макро эдийн засгийн нөхцөл байдал, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийж, Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийн танилцуулгад тусгасан. Мөн сар, улирлын	100%	100 %

158

							гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж "Сарын мэдээ", "Макро эдийн засгийн танилцуулга"-ыг англи, монгол хэл дээр улирал тутам бэлтгэж удирдлагууд, салбар яамд, УИХ-ын гишүүд, олон улсын байгууллага болон олон нийтэд хэвлэмэл болон цахим хэлбэрээр түгээн танилцуулсан. Хавсралт: 16 файл		
3.1.1	Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macro diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулж, танилцуулна.	Үйл ажиллагааны зардлааар	Дүн шинжилгээний тоо	Өмнөх онуудын эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн.	-	2024 оны түвшинд дүн шинжилгээ хийж танилцуулсан байна. /хийсэн тухай бүрийн танилцуулга/	Макро эдийн засгийн нөхцөл байдлын улирал тутмын танилцуулгад төсвийн чиглэлээр дүн шинжилгээ хийж, англи, монгол хэл дээр танилцуулгыг бэлтгэн хэвлэн нийтлүүлж удирдлагуудыг мэдээллээр	100%	100%

							ханган ажиллав. Мөн хэвлэн нийтлэсэн танилцуулгыг УИХ-ын гишүүд, салбар яамд, олон улсын байгууллагуудад хүргүүлж яамны цахим хуудсаар олон нийтэд хүргэн ажиллав. Хавсралт: 7 файл		
3.1.2	Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана.	Үйл ажиллагааны зардлааар	Мэдээллийн тоо /Тоо/	Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн.	-	Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/	Төсвийн орлого, зарлага, тэнцэл болон өрийн үзүүлэлтүүдийн сарын гүйцэтгэлээр танилцуулга бэлтгэж сар бүр удирдлагуудыг мэдээллээр ханган ажиллав. Хавсралт: 22 файл	100%	100%
3.1.3	Дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, И-баримт гэх мэт)	Үйл ажиллагааны зардлааар	Тайланд ашигласан тоо	-	-	Улирлын тайланд ашигласан байна. /3 удаа/	Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран ажиллаж, Гааль болон И-Баримт системийн өгөгдлийг тогтмол хүлээн	100%	90%

							авч боловсруулан, сар, улирлын тайлан, танилцуулгад дүн шинжилгээ хийж ажилласан. Танилцуулгад гаалийн орлого, НӨАТ-ын буцаан олголт, татварын хураамжийн гүйцэтгэл зэрэг гол үзүүлэлтүүдийн динамик өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж удирдлагад танилцуулан макро эдийн засгийн улирлын танилцуулга болон төсвийн хүрээний мэдэгдлийн танилцуулгад тусгасан болно. Хавсралт: 4 файл		
3.1.4	Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөлд ашиглана.	Үйл ажиллагааны зардлааар	Хөгжүүлсэн загварын тоо	Мэдээллийн дата баазыг бүрдүүлж, туршилт тооцооллуудыг гүйцэтгэсэн.	-	Загвар хөгжүүлсэн байна /1 загвар/	Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлэх Олон улсын валютын	100%	100%

							сангийн COVID stress test, PFRAM зэрэг эрсдлийн загвар болон төсөв санхүүгийн Financial programing and policy (FPP) загваруудыг өөрийн орны онцлогт тохируулан ажиллуулж, хөгжүүлэх Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад тооцоо, төсөөлөлд ашиглахаар хөгжүүлэлтийг хийн ажиллаж байна.		
3.2.	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлнэ.	-	-	-	-		Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн олон	100%	90%

						нийтийн хэлэлцүүлгийг 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр төрийн болон төрийн бус, судалгаа, шинжилгээний байгууллага, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага болон болон иргэдийн төлөөллийг оролцуулсан байдлаар цахим болон танхимын хэлбэрээр зохион байгууллаа. Олон нийтийн хэлэлцүүлгэд 100 гаруй хүн оролцсон бөгөөд нийт 300 хариу санал цахимаар болон цаасаар ирүүлсэн болно. “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны		
--	--	--	--	--	--	--	--	--

						төсвийн төсөөллийн тухай” хуулийн төслийг хуульд заасан тусгай шаардлагуудад нийцүүлэн боловсруулж, Засгийн газар болон УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж 2024.06.05-ны өдөр батлуулсан. Гэвч Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 11 дүгээр сарын 29- ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн		
--	--	--	--	--	--	---	--	--

							2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах эрх зүйн шаардлага үүссэн. Иймд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийг Ерөнхийлөгчийн тавьсан хоригт нийцүүлэн боловсруулж, 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн бариад байна. Хавсралт: 3 файл		
3.2.1	Монгол Улсын төсвийн дунд хугацааны эрсдэлийг тодорхойлж тайлан танилцуулга бэлтгэн, удирдлагад танилцуулна.	Үйл ажиллагааны зардлааар	Тайлангийн тоо	-	-	Тайлан боловсруулсан байна. /1 тайлан/	Төсвийн эрсдэлийн тайланг макро эдийн засгийн дүн	100%	100%

							шинжилгээнд тулгуурлан боловсруулж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр тогтмол ханган ажилласан. Тайлан боловсруулахда а төсвийн эрсдэлд нөлөөлж болзошгүй олон хүчин зүйлийн үнэлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах бодлогын санал, шийдлүүдийг тодорхойлон гаргав. Эрчим хүчний тасалдал: Эрчим хүчний хангамж доголдсоноор төсвийн зардал нэмэгдэх, эдийн засгийн салбаруудад үзүүлэх нөлөөллийг тооцоолов. Цаг агаарын хүндрэл (зуд, ган):		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							Байгалийн гамшиг, үүнтэй холбоотой мал аж ахуйн хорогдол болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн бууралтаас үүдэх орлогын алдагдлыг үнэлсэн. Мал амьтны өвчин: Мал аж ахуйн салбар дахь эрсдэл нь экспорт, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөөг тодорхойлон төсөвт учрах зардлыг тооцоолсон. Экспортын түүхий эдийн үнийн хэлбэлзэл: Дэлхийн зах зээл дээрх нүүрс, зэс зэрэг голлох бүтээгдэхүүний үнийн уналтаас үүдэн төсвийн орлогын багасалтад үзүүлэх нөлөөг нарийвчлан		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							шинжилсэн. Геополитикийн тогтворгүй байдал: Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын эрсдэлүүд болон олон улсын зах зээлд гарах хүндрэлээс үүдэн үүсэх төсвийн дарамтыг үнэлсэн. Нийлүүлэлтийн тасалдал: Гадаад болон дотоодын тээвэр, ложистикийн доголдлоос шалтгаалан үүсэх төсвийн зардлын нэмэгдлийг судалсан. Эдгээр эрсдэлүүдийн шинжилгээний үр дүнд төсөвт учирч болзошгүй хүндрэлүүдийг тодорхойлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр бодлогын		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							дараах санал, зөвлөмжүүдийг боловсруулсан. Тухайлбал, төсвийн эрсдэлийн нөөц санг нэмэгдүүлэх, зардлыг оновчтой хуваарилах, экспортын түүхий эдээс хамаарах хамаарлыг бууруулах олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатайг онцолсон болно. Хавсралт: 1 файл		
3.2.2	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаар олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардлаар	Хэлэлцүүлэг зохион байгуулсан тоо	-	-	Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан байна /1 хэлэлцүүлэг/	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2024 оны 3 дугаар сарын	100%	100%

							29-ний өдөр төрийн болон төрийн бус, судалгаа, шинжилгээний байгууллага, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага болон болон иргэдийн төлөөллийг оролцуулсан байдлаар цахим болон танхимын хэлбэрээр зохион байгууллаа. Олон нийтийн хэлэлцүүлгэд 100 гаруй хүн оролцсон бөгөөд нийт 300 гаруй санал цахимаар болон цаасаар ирүүлсэн болно. Хавсралт: 2 файл		
3.2. 3	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо,	Үйл ажиллагаан ы зардлааар	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсан.	-	Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2024- 2027 оны тооцоо, төсөөллийн танилцуулгыг	"Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026- 2027 оны төсвийн	100%	100 %

	төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.					боловсруулсан байна/ 1 танилцуулга/	төсөөллийн тухай” хуулийн төслийг боловсруулж, Засгийн газар болон УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж 2024.06.05-ны өдөр батлуулсан. Гэвч Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-		
--	---	--	--	--	--	-------------------------------------	--	--	--

							2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах эрх зүйн шаардлага үүссэн. Иймд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийг Ерөнхийлөгчийн тавьсан хоригт нийцүүлэн боловсруулж, 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн бариад байна. Хавсралт: 1 файл		
3.3.	Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн	-	-	-	-		Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж Монгол Улсын хөгжлийн 2025	100%	100%

	төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулна.					оны төлөвлөгөөний төслийн танилцуулгад тусгасан. Мөн дэлгэрэнгүй танилцуулга хэсэгт төсвийн орлого, зарлага болон өрийн өнөөгийн байдал цаашдийн чиг хандлагын талаар танилцуулгыг бэлтгэсэн. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг Монгол Улсын Засгийн газар, холбогдох байнгын хороодоор хэлэлцсэн бөгөөд Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батласан. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн		
--	--	--	--	--	--	--	--	--

							хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулийг боловсруулах хүрээнд макро эдийн засгийн нөхцөл байдал, дунд хугацаандах төсөөллийн талаар танилцуулгыг бэлтгэн хуулийн дэлгэрэнгүй танилцуулгад тусгасан. Хавсралт: 4 файл		
3.3.1	Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана.	Үйл ажиллагааны зардлаар	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" батлуулсан.	-	Монгол Улсын 2025 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж танилцуулсан байна. /1 танилцуулга /	Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийн танилцуулгад	100%	100%

155

							тусгасан. Мөн дэлгэрэнгүй танилцуулга хэсэгт төсвийн орлого, зарлага болон өрийн өнөөгийн байдал цаашдийн чиг хандлагын талаар танилцуулгыг бэлтгэсэн. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг Монгол Улсын Засгийн газар, холбогдох байнгын хороодоор хэлэлцсэн бөгөөд Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батласан. Хавсралт: 2 файл		
3.3.2	Улсын төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн хөгжлийн үндсэн	Үйл ажиллагааны зардлааар	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоол "Монгол	-	Эдийн засгийн 2025 оны тооцоо төсөөлөл, танилцуулга	Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх	100%	100%

	үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг гүйцэтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлнэ.			Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" батлуулсан.		бэлтгэх /1 танилцуулга/	чиглэлийг тодорхойлж Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийн танилцуулгад тусгасан. Мөн дэлгэрэнгүй танилцуулга хэсэгт төсвийн орлого, зарлага болон өрийн өнөөгийн байдал цаашдийн чиг хандлагын талаар танилцуулгыг бэлтгэсэн. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг Монгол Улсын Засгийн газар, холбогдох байнгын хороодоор хэлэлцсэн бөгөөд Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн		
--	---	--	--	--	--	--------------------------------	---	--	--


							батласан. Хавсралт: 1 файл		
3.3. 3	Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	Үйл ажиллагааны зардлааар	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсан.	-	Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2025 оны тооцоо, төсөөлөл, тэргүүлэх чиглэлийн танилцуулгыг боловсруулсан байна/ 1 танилцуулга/	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл танилцуулгыг боловсруулж, төсвийн танилцуулгад тусгав. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн бариад байна. Хавсралт: 3 файл	100%	100%

Үнэлсэн:

И.Батхүү

Төрийн нарийн бичгийн дарга

(албан тушаал)



/И.Батхүү/

(гарын үсэг)

2024.12.18

(огноо)

Тайлагнасан:

О.Мягмардорж

Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

(албан тушаал)

(гарын үсэг)

A handwritten signature in black ink, likely belonging to O. Myagmar Dorj, written over a dotted line.

/О.Мягмардорж./

2024.12.18

(огноо)

10